



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/536

Булган сум

“Аюулгүйн хонх” системийг суурилуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хуралдааны VII/38 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагдан хорих, баривчлах, эрүүлжүүлэх, саатуулах байранд иргэний амь нас хохирохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор “Аюулгүйн хонх” системийг суурилуулах шаардлагатай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1,920,000 (нэг сая есөн зуун хорин мянга) төгрөг, Цагдаагийн газарт 900,000 (есөн зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. “Аюулгүйн хонх” системийг шинээр суурилуулахад шаардлагатай 2,820,000 (хоёр сая найман зуун хорин мянга) төгрөгийг “Амар тайван Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. “Аюулгүйн хонх” системийг шинээр суурилуулах ажлыг чанартай гүйцэтгэн үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга (хурандаа Д.Төгсбаяр), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР